



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/553

Булган сум

“Алтаргана-2024” олон улсын XV их наадмын өдрүүдэд худалдаа үйлчилгээний газруудыг 24 цагаар үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 23 дугаар зүйлийн 23.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана-2024” олон улсын XV их наадмын өдрүүдэд Булган аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй болон бусад худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 24 цагаар тогтоосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), сумын Засаг дарга нарт, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараа дагаж мөрдсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0304010744